



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

Хэвлэлийн мэдээ

2019.04.15

Холбоо барих

+976 9511 7771

**Монгол Улсын гуравдагч хөршийн худалдааны
тухай хуулийн төслийг АНУ-ын Конгрессд өргөн барилаа**

*Монголын ноолуурын салбарт томоохон хөрөнгө оруулалт,
ажлын байр нэмэгдэж, өсөлтөд хүрэх боломжууд нээгдэж байна*

УЛААНБААТАР - Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам Монгол) нь АНУ-ын Конгрессийн зүгээс Монголын гуравдагч хөршийн худалдааны тухай хуулийг хэлэлцэх болсон мэдээг баяртай хүлээн авлаа. Уг хууль нь Монголын ноолууран бүтээгдэхүүнийг АНУ-ын зах зээлд татваргүй экспортлох боломжийг нээсэн АНУ-ын худалдааны санаачлага бөгөөд Монголын ноолууран болон нэхмэлийн үйлдвэрлэлийн өсөлтөд ихээхэн хувь нэмэр оруулах юм. АмЧам Монгол нь АНУ-ын Конгресс болон Трампын засаг захиргаанд Монголын гуравдагч хөршийн худалдааны тухай хуулийг (МУГХХТХ) шуурхай баталж хэрэгжүүлэхийг уриалж байна.

“МУГХХТХ-ийг батлах нь Монголын ноолуурын салбарын хөгжилд асар их өөрчлөлтийг авчрах болно,” гэж АмЧам Монголын ТҮЗ-ийн дарга Ойбек Халилов хэллээ. Халилов үргэлжлүүлэн, “Энэ бол маш зөв шийдэл бөгөөд Монголын болон Америкийн бизнес эрхлэгчид, ажилчдад ихээхэн ашиг тусаа өгөх болно,” хэмээн онцоллоо.

АмЧам Монгол нь энэхүү хууль тогтоомжийг дэмжиж байгаа Конгресс дахь хоёр намын удирдагчид тэр дундаа хуулийн төслийг анхлан санаачилсан болон хамтран дэмжиж буй Төлөөлөгчдийн танхмын гишүүд Дина Тайтус болон Тед Иохо, Дэвид Прайс, Жеймс Макговерн, Стив Кохен, Брайн Фитцпатрик, Ралф Норман, Дон Ёонг, болон Сенатын гишүүд болох Дэн Саливан, Бен Кардин, Кори Гарднер, Шелдон Вайтхаус, Дэвид Пердю болон Патрик Лейа нарт талархал илэрхийлж байна. Ирэх өдрүүдэд дэмжиж гишүүдийн тоо нэмэгдэх төлөвтэй байна.

“МУГХХТХ-г дэмжиж буй АНУ-ын Конгрессийн гишүүдийн цар хүрээ өргөн байгаа нь АНУ-д Монголыг хэрхэн өргөн дэмжиж буйн тод илрэл болж байна”, гэж АмЧамын үүсгэн байгуулагч Жэксон Кокс онцлон хэлэв. Кокс үргэлжлүүлэн, “Конгрессийн гишүүд энэ хууль тогтоомж Монголын эдийн засагт хэрхэн нөлөөлж, цаашлаад АНУ-ын ашиг сонирхолд яагаад чухал ач холбогдолтойг ойлгож байгаа” хэмээжээ.

Н.R. 2219/S. 1188 дугаартай энэ хууль батлагдсанаар дэлхийн хамгийн ашигтай зах зээл болох АНУ-д Монголоос гарал үүсэлтэй ноолуурыг татваргүй, квотгүй нэвтрүүлэх боломж олгох юм. Монголын ноолуур нь чанар, зөөлөн байдлаараа дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн боловч харамсалтай нь Монголын ноолуурын дийлэнх хэсгийг түүхийгээр нь БНХАУ-д хямд үнээр экспортлож, энэ нь Монголын эдийн засагт өгөөж багатай бөгөөд ноолуурын салбарыг бүрэн дүүрэн, цогцоор нь хөгжүүлэхэд саад учруулж байна.

Монгол Улс 2017 онд дэлхийн ноолуурын 50%-ийг үйлдвэрлэж 9400 тонн түүхий ноолуур үйлдвэрлэсний зөвхөн 1100 тонныг дотооддоо боловсруулалт хийсэн бөгөөд үлдсэн 8300 тонныг БНХАУ руу экспортложээ.

Ноолууран бүтээгдэхүүнийг импортын татвараас чөлөөлөх нь АНУ-д Монголын ноолуурын эрэлт хэрэгцээг бий болгох юм. Энэ эрэлт хэрэгцээг хангахын тулд Монголын ноолуурыг БНХАУ-д бус дотооддоо боловсруулж, Монголын ажилчдад зориулсан олон мянган шинэ ажлын байр бий болно.

Уг хууль тогтоомж нь АНУ-ын стратегийн сонирхлыг тэлэхээс гадна дэлхийн зах зээл дээрх АНУ-ын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм. Монгол улсын байгуулсан олон улсын худалдааны гэрээний дагуу Монголын ноолуурыг Европын Холбоо болон Япон улс руу татваргүй экспортлох боломжтой байгаа билээ. МУГХХТХ нь Монголын ноолуурын салбарын өрсөлдөөнд АНУ-д таатай нөхцөл байдал олгож байгаа юм. Ингэснээр АНУ-ын жижиг дунд бизнесүүд, жижиглэнгийн худалдаачид мөн хэрэглэгчдэд ч шинэ боломжууд гарч ирэх юм.

2012 онд хоёр улсын нийт худалдааны эргэлт 707 сая ам. долларт хүрч дээд хэмжээнд хүрч байсан бол 2017 онд Монгол Улс 9.4 сая ам. долларын экспорт, 82.2 сая ам. долларын бараа бүтээгдэхүүн импортолжээ. Цаашид экспорт, импорт өсөн нэмэгдэх бүрэн боломжтой юм. Гуравдагч хөршийн худалдааны тухай хууль нь Монгол улсын оёдлын салбарт 40,000 ажлын байрыг шинээр бий болгож нэн ялангуяа эмэгтэйчүүд ажлаар хангагдах болно. Энэ тоо нь энэхүү хуулийн үзүүлэх шууд үр нөлөө бол шууд бус үр ашиг нь хэмжээшгүй их бөгөөд хүн амын гуравны нэг нь мал аж ахуйн салбарт ажилладаг Монгол улсын хувьд ноолуур нь эдгээр хүмүүсийн дийлэнхийн хувьд орлогын эх үүсвэр билээ.

2017 онд Монгол улс АНУ-тай дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг тэмдэглэсэн юм. ОХУ, БНХАУ хэмээх хоёр хөрштэй, далайд гарцгүй Монгол улсын хувьд АНУ нь стратегийн гуравдагч хөрш гэж тодорхойлогддог. 1990-ээд оны эхээр ЗХУ-ын дэглэм унаснаас хойш АНУ нь Монголын ардчилсан өөрчлөлт шинэчлэлийг олон төрлийн санаачлагаар дэмжиж ирсэн билээ. Монгол улсад зориулсан Мянганы сорилтын сангийн хоёр дахь компакт гэрээг баталсан. Монгол улс 2003 оноос хойш Ирак, Афганистан дахь АНУ-ын энхийг сахиулах ажиллагааг дэмжиж ирсэн бөгөөд энэ нь Монгол Улс ардчилсан үзэл санаа, хүний эрх, эрх чөлөө, чөлөөт зах зээлийн эдийн засгийн үнэт зүйлсийг дээдэлдгийн илрэл юм.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхimuудыг

